



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/310

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэхь заалт, Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгж, харьяа агентлаг, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3.“Журам батлах тухай” Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/87 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Б.ДЭЛГЭРСАЙХАН

Зам, тээврийн сайдын 2025 оны
11 дугаар сарын 25-ны өдрийн
А/310 дугаар тушаалын хавсралт

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГ,
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ,
ҮНЭЛЖ ДҮГНЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллага (цаашид яам болон агентлаг, байгууллага гэх)-ын үйл ажиллагаа болон хөгжлийн бодлогын баримт бичиг (цаашид бодлогын баримт бичиг гэх), хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү журмын зорилго нь зам, тээврийн салбарын бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах, хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлтэд үндэслэн бодлогын хувилбар, санал, зөвлөмжийг боловсруулж, удирдлагад бодлогын дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлага, зохион байгуулалт

2.1. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, үнэлж дүгнэх ажлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавих, мэдээлэх үүргийг салбарын хэмжээнд сайд, агентлаг, байгууллагын хэмжээнд дарга (захирал) нар тус тус хэрэгжүүлнэ.

2.2. Яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж нь зам, тээврийн салбарын хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, яам болон харьяа агентлаг, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж, ажилтанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна.

2.3. Харьяа агентлаг, байгууллагууд нь хяналт-шинжилгээний асуудал хариуцсан нэгж, эсхүл ажилтан (баг)-тай байх бөгөөд хяналт-шинжилгээний асуудал хариуцсан нэгж, эсхүл ажилтан (баг) нь зохион байгуулалтын хувьд бусад нэгжээс хараат бусаар үйл ажиллагаа явуулна.

2.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан тушаалтан дараах мэргэшлийн шаардлагыг хангасан байна:

2.4.1. хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр болон тухайн салбарт ажилласан туршлагатай байх;

2.4.2. хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр мэргэшүүлэх урт, богино хугацааны сургалтад хамрагдсан байх;

2.4.3.баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх ур чадвартай байх.

2.5. Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг төрийн захиргааны удирдлагын болон бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж хамтран, харьяа агентлаг, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг захиргаа, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж (байгууллага зохион байгуулалтын нэгжгүй бол ажлын хэсэг байгуулж болно.) бусад нэгжүүдийн саналыг авч нэгтгэн боловсруулж, байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, тухайн жилийн 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор төсвийн шууд захирагч батална.

2.6. Яамны нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийцүүлэн холбогдох нэгжүүд боловсруулж, тухайн жилийн 01 дүгээр сарын 07-ны өдрийн дотор төсвийн шууд захирагч батална.

2.7. Яам, нэгжүүдийн болон харьяа агентлаг, байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг яамны холбогдох бодлого зохицуулалтын болон бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгжүүд хянаж, баталгаажуулах ажлыг төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан нэгж зохион байгуулна.

2.8. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал (зохицуулагч)-тай байгуулах Хөлсөөр ажил гүйцэтгэх гэрээг тухайн салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах нэгж нь хянан Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан нэгж баталгаажуулах ажлыг зохион байгуулна.

2.9. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч тухайн жилийн явцад зайлшгүй хийх шаардлагатай болсон салбарын хөгжлийн бодлогыг тодорхойлох, эсвэл хэрэгжилтийг зохицуулахад тодорхой үр дүнгээ өгөх ажлыг нэмэлт ажил, үйлчилгээнд тооцон үнэлнэ.

2.10. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээ тус бүрд хэрэгжүүлэх хугацааг тодорхой зааж өгнө. Энэхүү хугацааг сар, улирлаар тогтоох ба улирлаас урт хугацаанд үргэлжлэн хийгдэх ажлын хүрэх түвшинг улирал бүрээр тодорхой зааж төлөвлөсөн байна.

2.11. Яамны нэгж, харьяа агентлаг, байгууллагын дарга (захирал) нар энэхүү журмын 3 дугаар хавсралтад заасан тайлан, мэдээллийг хугацаанд нь тоон гарын үсгээр баталгаажуулан нотлох баримтын хамт цахим хэлбэрээр khynalt@mrt.gov.mn хаягаар ирүүлнэ.

2.12. Тайлан, мэдээ нь тухайн нэгж, агентлаг, байгууллагын үйл ажиллагааны хүрсэн үр дүн, гүйцэтгэсэн ажлын чанарыг бүрэн, тодорхой илэрхийлсэн байх ба үнэн зөв байдлыг нэгж, агентлаг, байгууллагын дарга (захирал) нар хариуцна.

2.13. Байгууллагын ажилтан, албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг энэхүү журмын 4 дүгээр, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг 5 дугаар, Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудитын хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 6 дугаар, эрсдэл бууруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг 7 дугаар хавсралтын дагуу тайлагнана.

2.14. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал (зохицуулагч)-тай байгуулсан хөлсөөр ажил гүйцэтгэх гэрээг дүгнэх ажлыг тухайн салбарын бодлого зохицуулалт асуудал хариуцсан нэгж зохион байгуулна.

2.15. Яамны Бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж нь бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан нэгж нь хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал, яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг журмын 3 дугаар хавсралтад заасан хугацаанд яамны нэгж, харьяа агентлаг, байгууллагуудаас тус тус авч нэгтгэх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж түүнд хяналт-шинжилгээ хийж, тайланг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

2.16. Хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж нь харьяа агентлаг, байгууллагын үйл ажиллагааны явцад хагас жил тутам, яам болон яамны нэгжийн үйл ажиллагаанд улирал тутам журмын 1, 2 дугаар хавсралтад заасан үзүүлэлтүүдээр хяналт-шинжилгээ хийх бөгөөд дараа сарын эхний 10 хоногт багтаан яамны нэгжийн тайланг Төрийн нарийн бичгийн даргад, яам болон харьяа агентлаг, байгууллагын тайланг сайдад тус тус танилцуулж, дүгнүүлнэ.

2.17. Хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж нь бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган, шаардлагатай зардлыг байгууллагын төсөвт төлөвлөж, батлуулан, холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулна.

2.18. Яам болон агентлаг, байгууллага нь жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг батална. Яамны төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн дарга, агентлаг, байгууллагын төлөвлөгөөг тухайн байгууллагын дарга (захирал) тус тус батална. Энэхүү төлөвлөгөө нь тухайн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгжийн төлөвлөгөө байж болно. Төлөвлөгөөнд зорилго, зорилт, хамрагдах байгууллага, нэгж, хэрэгжүүлэх хугацаа, зардал, хамтран оролцох байгууллага зэргийг тусгана.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал

3.1. Яам, яамны нэгж, харьяа агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэхэд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам", Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам" болон холбогдох бусад баримт бичиг, аргачлалуудыг ашиглана.

3.2. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүнг дараах аргачлалаар тооцож, хувиар илэрхийлнэ:

$$\text{Хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} \cdot 100\%$$

3.3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг дараах аргачлалаар дүгнэнэ:

3.3.1. “хэрэгжсэн”-үүрэг, даалгаврын хэрэгжилт бүрэн хангагдсан (зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, төсөв санхүүгийн асуудлыг шийдэж, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, удирдах дээд байгууллагад өргөн барьсан гэх мэт төлөвлөсөн үр дүн гарсан);

3.3.2. “хэрэгжээгүй”-(шийдвэрийн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа, бэлтгэл ажил, боловсруулалтын шатанд байгаа, төсөв шийдэгдсэн боловч хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй);

3.3.3. “хугацаа болоогүй”-(шийдвэрт тусгайлан заасан хугацаа болоогүй, эсхүл өөрөөс хамаарах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн боловч бусад¹ хүчин зүйлээс шалтгаалан хэрэгжилт хангагдаагүй, мөн урт хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай бол -(ХБ)).

3.3.4. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн ерөнхий дүнг дараах томъёогоор тооцож гаргана:

$$\frac{\text{Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дүн}}{\text{Хэрэгжсэн заалтын тоо}} = \frac{\text{Хэрэгжсэн заалтын тоо}}{(\text{Нийт заалтын тоо} - \text{Хугацаа болоогүй заалтын тоо})} \times 100\%$$

3.3.5. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хоёр удаагийн тайлангийн хугацаанд дараалан ахиц гараагүй бол удааширсан, гурван удаагийн тайлангийн хугацаанд мөн ахиц гараагүй бол тасарсанд тооцож, шалтгаан нөхцлийг тодорхойлон дараагийн шийдвэр гаргах шаардлагатай гэж үзнэ.

3.4. Стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө, Зам, тээврийн сайдын аймаг, Нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээ, “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, байгууллагын ажилчин, албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхэд бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг үнэлэх аргачлалыг, Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал, эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудитын хүрээнд өгсөн зөвлөмж, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэх аргачлалыг, нээлттэй мэдээллийн ил тод байдлыг 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх” журамд заасан аргачлалыг тус тус баримтална.

3.5. Зам, тээврийн сайдын аймаг, Нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээ, Санамж бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг нийт байгуулсан гэрээ, санамж бичгийн хэрэгжилтийн арифметик дунджаар үнэлнэ.

¹ гадаад хүчин зүйлээс шалтгаалсан болохыг баримтаар нотолсон байх;

3.6. Аргачлалын дагуу үнэлсний дараа тухайн нэгж, харьяа агентлаг, байгууллагын үйл ажиллагааны чанарыг үнэлэх зорилгоор төлөвлөгөөт хугацаа болон ажлын чанараас хамаарч дараах байдлаар үнэлнэ. Үүнд:

3.6.1. Холбогдох нотлох баримтыг хавсаргаагүй бол 10 хувь, цаглаварт заасан хугацаанд хэрэгжилтийг тайлагнаагүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутам 1 хувь, зөв бичих дүрэм, утга найруулгын алдаатай тайлагнасан бол 5 хувийг тухайн үзүүлэлт бүрийн ерөнхий дүнгээс тус тус хасаж тооцно.

3.6.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж нь тухайн ажлыг холбогдох шалгуурын дагуу үнэлэхдээ ажлын чанараас хамааран 10% өсгөх буюу бууруулж үнэлж болно.

3.7. Тайлан ирүүлээгүй арга хэмжээг "тасарсан" буюу "тэг хувь" гэж үнэлнэ.

3.8. Байгууллага, нэгжийн үйл ажиллагааны нэгдсэн дүнг гаргахдаа үзүүлэлт бүрийн хэрэгжилтийн хувийг тухайн үзүүлэлтийн жинлэсэн оноогоор үржүүлэн нийлбэрийг нийт жинлэсэн онооны нийлбэрт хуваана.

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан

4.1. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлэх, тайлан илгээх, хүлээн авах, мэдээллийн урсгалыг удирдах, хянах, хадгалах, ашиглах, түгээхэд яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгжийн хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (цаашид "цахим сан" гэх)-г ашиглана.

4.2. Яамны хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санг ашиглах зааврыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж боловсруулан батлуулж, агентлаг, байгууллагыг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.

4.3. Яамны удирдлага, холбогдох албан тушаалтан цахим санд өөрийн эрхээр нэвтэрч бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайлантай танилцаж болно.

4.4. Хэрэгжилтийн тайланг цахим санд оруулахдаа тухайн зорилт, арга хэмжээ, заалтын хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаах бөгөөд шаардлагатай бол нотлох баримтыг цахим хэлбэрээр хавсаргана.

4.5. Цахим санд мэдээлэл оруулж байгаа яамны нэгж, харьяа агентлаг, байгууллагын удирдлага, албан хаагч мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хариуцна.

4.6. Яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж дор дурдсан асуудлыг хариуцна:

4.6.1. мэдээллийн санд нэвтрэх эрх олгох асуудлыг зохицуулах;

4.6.2. цахим санд өөрт олгосон эрхийн дагуу бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалт нэг бүрийг хяналтад авч, хугацааг зааж, холбогдох өөрчлөлтийг тухай бүр хийх;

4.6.3. цахим санд өөрт олгогдсон эрхийн дагуу нэвтэрч, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

4.6.4. цахим сангийн үйл ажиллагаатай холбоотой сургалт, зааварчилгаа, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах;

4.6.5. бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, яамны гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд тайлагнах;

4.7. Мэдээллийн сан, сүлжээний хэвийн, найдвартай ажиллагаа болон программ хангамж, системийн зохицуулалт, хөгжүүлэлтийг яамны мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж хариуцан зохион байгуулна.

Тав. Хяналт-шинжилгээ болон үнэлгээний үр дүнг хэрэгжүүлэх

5.1. Яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

5.1.1. хяналт-шинжилгээ болон үнэлгээний тайланд яамны нэгж, харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхүйц, үр өгөөжийг дээшлүүлэх, үйл ажиллагааг сайжруулахад мөрдлөг болохуйц тодорхой санал, зөвлөмжийг тусгах;

5.1.2. бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах, уялдааг сайжруулах, хүчингүй болгох, хяналтаас хасах, үнэлгээ хийх санал гаргах;

5.1.3. яам болон харьяа агентлаг, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;

5.1.4. шаардлагатай тохиолдолд зохих удирдамжийн дагуу газар дээр нь хяналт шалгалт хийх, дүгнэлт гаргах;

5.1.5. тухайн жилд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг холбогдох журмын дагуу архивын хадгаламжийн нэгж болгон бүрдүүлж, дараа оны нэгдүгээр улиралд багтаан яамны архивд хүлээлгэн өгөх;

5.2. Яамны нэгж болон харьяа агентлаг, байгууллагууд нь хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд дурдсан зөвлөмж, дүгнэлтийн дагуу дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.2.1. хэрэгжилтийг эрчимжүүлэх, нөөцийг оновчтой хуваарилж, зохион байгуулалтыг сайжруулах,

5.2.2. хэрэгжээгүй болон хэрэгжилт хангалтгүй арга хэмжээг дараа оны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг хангах;

5.2.3. бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох болон шаардлагатай бусад арга хэмжээ авах;

5.2.4. зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг журамд заасан хугацаанд тайлагнах;

Долоо. Хариуцлага

7.1. Үйл ажиллагааны үнэлгээний дүнгээр хоёр удаа хангалтгүй үнэлгээ (60-аас доош хувь) авсан яамны нэгж, агентлаг, байгууллагын дарга (захирал)-д Төрийн албаны тухай болон холбогдох бусад хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----- олоо -----

“Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг
байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж,
үнэлж дүгнэх журам”-ын 1 дүгээр хавсралт

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ДҮН

0024070592 5915A67 CST-5-57899

Үзүүлэлт		Хэрэгжилтийн хувь	Жин
1	2	3	4
Бодлогын үр дүн	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт		20
	Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт		20
Чиг үүргийн үзүүлэлтийн дүн (үнэлгээ)	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт		20
	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт		20
	Сайдын тушаалын хэрэгжилт		10
	Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт		10
	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ		10
Чадамжийн үнэлгээ	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт		10
	Зам, тээврийн сайдын аймаг, Нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээ, "Санамж бичиг"-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт		10
	Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт		15
	Эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт		5
	Байгууллагын ажилтан, албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хэрэгжилт		10
Ерөнхий дүн			

----- oOo -----

“Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг,
байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж,
үнэлж дүгнэх журам”-ын 2 дугаар хавсралт

ХАРЬАА АГЕНТЛАГ, БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ДҮН

0024070612 5913627 0511-157090

Үзүүлэлт		Хэрэгжилтийн хувь	Жин
1	2	3	4
Бодлогын үр дүн	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт		20
	Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт		20
	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт		20
Чиг үүргийн үзүүлэлтийн дүн (үнэлгээ)	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт		20
	Сайдын тушаалын хэрэгжилт		10
	Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт		10
	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ		10
Чадамжийн үнэлгээ	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт		10
	Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт		15
	Эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт		5
	Байгууллагын ажилтан, албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хэрэгжилт		10
Ерөнхий дүн			

----- oOo -----

"Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг,
байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж,
үнэлж дүгнэх журам"-ын 3 дугаар хавсралт

**ЯАМНЫ НЭГЖ, ХАРЬАА АГЕНТЛАГ,
БАЙГУУЛЛАГУУДЫН ТОГТМОЛ ГАРГАХ
ТАЙЛАН, МЭДЭЭЛЛИЙН НЭР ТӨРӨЛ, ХУГАЦАА**

№	Тайлан, мэдээллийн нэр	Яаманд ирүүлэх тайлан, мэдээлэл				Засгийн газар болон холбогдох бусад байгууллагад өгөх тайлан, мэдээлэл		
		Хугацаа	Хариуцан гаргах газар (хэлтэс, байгууллага)	Хүлээн авах газар	Хугацаа	Хариуцан нэгтгэж гаргах газар	Хүлээн авах байгууллага	
1	2	3	4	5	6	7	8	
Нэг. Улиралд								
1.1.	Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	03, 06, 09, 12 дугаар сарын 15-ны дотор	Яамны нэгжүүд	ТЗУГ	07 дугаар сарын 09, 02 дугаар сарын 01-ний дотор	СХШУДАГ	ЗГХХГ	
1.2.	Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	03, 06, 09, 12 дугаар сарын 15-ны дотор	Яамны нэгжүүд	СХШУДАГ	Улирал бүрийн дараа сарын 10-ны дотор	СХШУДАГ		
1.3.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	03, 06, 09, 12 дугаар сарын 10-ны дотор	Яамны нэгжүүд	БТГ	12 дугаар сарын 20, 07 дугаар сарын 01-ний дотор	СХШУДАГ	ЗГХХГ	
1.4.	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	03, 06, 09, 12 дугаар сарын 10-ны дотор	Яамны нэгжүүд	БТГ	01 дүгээр сарын 01, 07 дугаар сарын 01-ний дотор	СХШУДАГ	ЗГХХГ	
1.5.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	03, 06, 09, 12 дугаар сарын 10-ны дотор	Яамны нэгжүүд, харьяа агентлаг, байгууллагууд	ТЗУГ	01 дүгээр сарын 15, 07 дугаар сарын 01-ны дотор	СХШУДАГ	ЗГХЭГ	
1.6.	Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт	03, 06, 09, 12 дугаар сарын 15-ны дотор	Яамны нэгжүүд, харьяа агентлаг, байгууллагууд	СХШУДАГ	Улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор	СХШУДАГ		

1.7.	Төрийн нарийн бичгийн дарга тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт	03, 06, 09, 12 дугаар сарын 15-ны дотор	Яамны нэгжүүд, харьяа агентлаг, байгууллагууд	СХШУДАГ	Улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор	СХШУДАГ	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага.
1.8.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	03, 06, 09, 12 дугаар сарын 20-ны дотор	Яамны нэгжүүд, харьяа агентлаг, байгууллагууд	СХШУДАГ	Улирал бүрийн дараа сарын 25-ны дотор	СХШУДАГ	
Хоёр. Хагас, бүтэн жилд							
2.1.	Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөл	12 дугаар сарын 15-ны дотор	Яамны нэгжүүд	БТГ, ТЗУГ	12 дугаар сарын 25-ны дотор	БТГ, ТЗУГ	СХШУДАГ
2.2.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөл	12 дугаар сарын 15-ны дотор	Яамны нэгжүүд	БТГ, ТЗУГ	12 дугаар сарын 25-ны дотор	БТГ, ТЗУГ	СХШУДАГ
2.3.	Харьяа агентлаг, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөл	12 дугаар сарын 15-ны дотор	харьяа агентлаг, байгууллагууд	СХШУДАГ, Бодлого зохицуулалтын нэгжүүд	12 дугаар сарын 25-ны дотор	БТГ	ТЗУГ
2.4.	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захиралтай байгуулах хөлсөөр ажил гүйцэтгэх гэрээний төсөл	12 дугаар сарын 15-ны дотор	Төсөл хэрэгжүүлэх нэгж	Бодлого зохицуулалтын нэгжүүд	12 дугаар сарын 20-ны дотор	СХШУДАГ	ТЗУГ
2.5.	Зам, тээврийн сайдын аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах гэрээ, Санамж бичгийн төсөл	12 дугаар сарын 15-ны дотор	Яамны нэгжүүд, харьяа агентлаг, байгууллагууд	ТЗУГ			
2.6.	Харьяа агентлаг, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	06, 12 дугаар сарын 20-ны дотор	харьяа агентлаг, байгууллагууд	СХШУДАГ	Хагас, бүтэн жилийн дараа сарын 10-ны дотор	СХШУДАГ	
2.7.	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн захиралтай байгуулсан хөлсөөр ажил гүйцэтгэх гэрээний тайлан	12 дугаар сарын 10-ны дотор	Төсөл хэрэгжүүлэх нэгж	Бодлого зохицуулалтын нэгжүүд	12 дугаар сарын 20-ны дотор	СХШУДАГ	ТЗУГ
2.8.	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050"-ын хэрэгжилт	08 дугаар сарын 10-ны дотор	Яамны нэгжүүд, харьяа агентлаг, байгууллагууд	БТГ	10 дүгээр сарын 01-ны дотор	СХШУДАГ	ЗГХХГ

2.9.	Хөгжлийн хэрэгжилт	зорилтот	хөтөлбөрийн	08 дугаар сарын 01-ний дотор	Яамны нэгжүүд, харьяа агентлаг, байгууллагууд	БТГ	09 дүгээр сарын 01-ний дотор	СХШУДАГ	ЗГХХГ
2.10.	Төрөөс баримтлах бодлогын хэрэгжилт			Дараа оны 02 дугаар сарын 01-ний дотор	Яамны нэгжүүд, харьяа агентлаг, байгууллагууд	СХШУДАГ	Дараа оны 05 дугаар сарын 01-ний дотор	СХШУДАГ	
2.11.	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт (улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн хамт)			06, 12 дугаар сарын 10-ны дотор	Яамны нэгжүүд, харьяа агентлаг, байгууллагууд	БТГ	Дараа оны 01 дүгээр сарын 01-ний дотор	СХШУДАГ	ЗГХХГ
2.12.	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт			02 дугаар сарын 10-ны дотор	Яамны нэгжүүд, харьяа агентлаг, байгууллагууд	СХШУДАГ	Дараа оны 03 дугаар сарын 01-ний дотор	СХШУДАГ	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх "Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл"
2.13.	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ			06, 12 дугаар сарын 20-ны дотор	Яамны нэгжүүд, харьяа агентлаг, байгууллагууд	СХШУДАГ	Дараа оны 02 дүгээр сарын 01-ний дотор	СХШУДАГ	
2.14.	Байгууллагын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт			12 дугаар сарын 20-ны дотор	Яамны нэгжүүд, харьяа агентлаг, байгууллагууд	СХШУДАГ	Дараа оны 02 дугаар сарын 01-ний дотор	СХШУДАГ	ЗГХХГ

2.15.	Зам, тээврийн сайдын нийслэлийн Засаг даргатай байгуулсан Санамж бичгийн хэрэгжилт	Улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор	Яамны нэгжүүд	СХШУДАГ	Дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор	СХШУДАГ	
2.16.	Зам, тээврийн сайдын аймгийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилт	Жилийн сүүлийн сарын 25-ны дотор	Яамны нэгжүүд	ТЗУГ	Дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор	СХШУДАГ	
2.17.	Яамны үйл ажиллагааны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан				Дараа оны 02 дугаар сарын 01-ний дотор	СХШУДАГ	Сайд
2.18.	Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	06, 12 дугаар сарын 01-ний дотор	Яамны нэгжүүд, харьяа агентлаг, байгууллагууд	СХШУДАГ	Хагас, бүтэн жилийн сүүлийн сарын 30-ны дотор	СХШУДАГ	ЗГХХГ, Дотоод аудитын хороо
2.19.	Эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	05, 11 дүгээр сарын 01-ний дотор	Яамны нэгжүүд, харьяа агентлаг, байгууллагууд	СХШУДАГ	02 дугаар сарын 01-ний дотор	СХШУДАГ	ЗГХХГ

----- o0o -----

ЛЛААГ ХАНГАХ

(..... оны улирлын байдлаар)

14

			Удирдах албан тушаалтан Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	-
			Гадаад сургалтад хамруулсан байдал:	10-аас дээш	-
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал	2.3	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	Тайлант оны гүйцэтгэлээр	
		3.1	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь (15%-аас доош байх)	$\frac{\text{чөлөөлөгдсөн албан хаагч}}{\text{албан хаагчдын дундаж}} * 100\%$	
		4.1	Шатлан дэвшүүлсэн албан хаагчийн тоо		
		4.2	Эмэгтэй албан хаагч		
		Үүнээс	Эрэгтэй албан хаагч	-	-
4.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	Үүнээс	Удирдах албан тушаалтан	-	-
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	-
		4.3	Шилжүүлсэн болон сэлгэн ажиллуулсан албан хаагчийн тоо	-	-
			Эмэгтэй албан хаагч	-	-
		Үүнээс	Эрэгтэй албан хаагч	-	-
			Удирдах албан тушаалтан	-	-
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	-
		Нийгмийн баталгааг хангах хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ			
	Албан хаагчид олгосон цалин урамшуулал, нөхөх төлбөр, тусламж, дэмжлэг			-	Тайлант оны гүйцэтгэлээр
	Нийт албан хаагчийн тоо			-	-
	Урамшуулал олгосон албан хаагчийн тоо			-	-
	Үүнээс		удирдах	-	-
			гүйцэтгэх	-	-
5.	5.1.Улирлын урамшуулал олгосон байдал	Нийт олгосон урамшууллын хэмжээ		-	-
		Үүнээс	I улирал	-	-
			II улирал	-	-

5.3.2.өрдийн галлагаатай сууцанд амьдардаг төрийн албан хаагчид өвлийн улирлын түлш худалдан авах зардлын зохих хэсгийг байгууллагаас нөхөн олгож болно. ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.3)	нөхөх төлбөрийн хэмжээ		
5.3.3.төрийн албанаас түр чөлөөлөгдсөн тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчид тухайн албан хаагчийн албан тушаалын 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.5)	албан хаагчийн тоо		
5.3.4.Төрийн албан хаагчийг эрхэлсэн ажил, эзэмшсэн мэргэжлийн дагуу 180 хүртэл хоногийн хугацаагаар эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу төрийн хөрөнгө, бусад эх үүсвэрээр давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэхэд түүний эрхэлж байгаа албан тушаалын цалинг олгоно. ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.6)	нөхөх төлбөрийн хэмжээ		
5.4 Албан хаагчид олгосон тусламж, нийт:	албан хаагчийн тоо	-	-
5.4.1.өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн албан хаагчид олгосон нэг удаагийн буцалтгүй тусламж	нөхөх төлбөрийн хэмжээ	-	-
5.4.2.албан үүргээ гүйцэтгэх явцад амь нас хохирсон албан хаагчийн ар гэрт олгосон нэг удаагийн буцалтгүй тусламж	албан хаагчийн тоо	-	-
5.5. Албан хаагчийн нийтлэг баталгаанд зарцуулсан зардал, нийт:	нөхөх төлбөрийн хэмжээ	-	-
5.5.1.эзлэгийн амралтаа биеэр эдэлж чадаагүй албан хаагчид 1.5 сарын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгосон	албан хаагчийн тоо	-	-
5.5.2.орон байраар хангагдахад байгууллагаас үзүүлсэн дэмжлэг	нөхөх төлбөрийн хэмжээ	-	-
	албан хаагчийн тоо	-	орон байрны нөхцөл сайжруулах -шинэ гэр, байшин авах

				-шинээр газар олгосон гэх мэт бодит дэмжлэгийн талаар бичих
		зарцуулсан хөрөнгийн хэмжээ	-	-
	5.5.3.албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг сайжруулахад зарцуулсан зардал	зарцуулсан хөрөнгийн хэмжээ	-	Ажлын байрны нөхцөлийг хэрхэн сайжруулсан тухай мэдээллийг товч тайлагнах
	5.5.4.албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэг (жилд) 1-ээс дээш	албан хаагчийн тоо зарцуулсан хөрөнгийн хэмжээ	- -	Төрөлжсөн болон багц шинжилгээний талаар бичих

--- o0o ---

"Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг,
байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж,
үнэлж дүгнэх журам"-ын 5 дугаар хавсралт

НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТ

(..... оны улирлын байдлаар)

№	Нээлттэй мэдээлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Мэдээний линк	Үнэлгээ				Хэрэгжилт хувь
				"Мэдээллийн хүртээмжтэй байдал"-ыг (МХБ)	Хугацаандаа нийтлэгдсэн байдал"-ыг (ХНБ)	"Мэдээллийн бүрэн бүтэн байдал"-ыг (МБББ)	"Эх сурвалжийн тодорхой байдал"-ыг (ЭСТБ)	
Нэг.Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал								
1.1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн							
1.2	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг							
1.3	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж							

[illegible]

	өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр								
3.9	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл								
3.10	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан								
3.11	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт								
3.12	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл								
3.13	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн								
3.14	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан								

Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал									
4.1	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл								
4.2	Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.								
Тав.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал									
5.1	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал								
5.2	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт								
5.3	Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл								
5.4	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл								

5.5	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг									
5.6	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл									
5.7	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл									
5.8	Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл									

5.14	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлт									
5.15	Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэл									
5.16	Хууль болон олон Улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл									

----- ооо -----



"Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг,
байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж,
үнэлж дүгнэх журам"-ын 6 дугаар хавсралт

ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГААС ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, АУДИТ,
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

(..... оны улирлын байдлаар)

№	Илэрсэн асуудал	Мөнгөн дүн (мян.төг)	Өгсөн зөвлөмж	Зөвлөмжийн хэрэгжилт	Гүйцэтгэлийн түвшин				Үнэлгээ (хувиар)
					Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болгоогүй		
1	2	3	4	5	6	7	8		10
1.Төлбөрийн акт									
1									
2									
	Дүн								
2.Албан шаардлага									
1									
2									
	Дүн								
3.Зөвлөмж									
1									
2									
3									
	Дүн								
	Нийт дүн								

----- ооо -----



"Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг,
байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж,
үнэлж дүгнэх журам"-ын 7 дугаар хавсралт

**ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ**

(..... оны улирлын байдлаар)

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Арга хэмжээний хэрэгжилт	Үнэлгээ /Хэрэгжсэн, Хэрэгжээгүй, Хугацаа болоогүй/
1						
2						
3						

----- ооо -----